

**АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Хурлын огноо: 2024 оны 4 сарын 25-ны өдөр;

Хурлын байршил: Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сүхбаатарын талбай 2, Сэнтрал тауэр барилгын 17 давхарт “Ард Санхүүгийн нэгдэл” ХК-ийн байр

Хурал эхэлсэн цаг: 11:00 цаг;

Хурлын дарга: Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Цаашид “ТУЗ” гэх)-ийн дарга Ч.Ганзориг;

Хуралд оролцсон удирдлагын багийн гишүүн: ТУЗ-ийн Хараат бус гишүүн Б.Солонго, ТУЗ-ийн гишүүн, Ард санхүүгийн нэгдлийн гүйцэтгэх захирал Б.Золбоо, Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар, Санхүү Эрхэлсэн Захирал Д.Лхагва-Очир,

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. Компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх;
4. 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах;
5. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэх;

Хурлын ирцийн танилцуулга: Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл

Ард кредит ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 24/01 тогтоолыг танилцуулъя.

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.7, 67 дугаар зүйлийн 67.3, 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2 дахь хэсэг, Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 285,206,770 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 178 /нэг зуун далан найм/ хувьцаа эзэмшигчид оролцож байна. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2 дахь заалтыг тус тус үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны **78.35** хувь эзэмшдэг хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа тул хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт болно.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН САНАЛ: Хурлын ирцтэй холбогдуулан Хувьцаа эзэмшигчдээс санал гаргаагүй болно.

ХЭХ-ийн нээлт, хурлын дэг танилцуулах: Хурлын дарга Ч.Ганзориг

“Ард Кредит ББСБ” ХК нь Ард санхүүгийн нэгдлийн томоохон компаниудын нэг бөгөөд 15,000 гаруй хувьцаа эзэмшигчтэй болсон байна. Та бүхний мэдэж байгаачлан энэ жил бид FPO буюу нэмэлт хувьцааг хөрөнгийн бирж дээр амжилттай гаргаж, 8,000,000,000 төгрөгийг босгож, хувьцаа эзэмшигчдийн тоо өсгөсөн. Кripto валютын өвөл дуусч зун ирж байгаа тул Ард санхүүгийн нэгдэл энэ долоо хоногийг Кripto долоо хоног нэртэйгээр хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлыг хийж байгаа. Хурлын дэгийг та бүхэнд танилцуулъя. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар, 2023 оны санхүүгийн тайланг Санхүү эрхэлсэн захирал Д.Лхагва-Очир, Компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг Грант Торнтон Аудит

танилцуулах, Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Солонго, 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах өөрчлөлтийг гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар нар тус тус танилцуулна. Өнөөдрийн хуралд компанийн удирдлагын баг, ТУЗ-ийн гишүүд ирсэн байгаа. Хувьцаа эзэмшигч та бүхэн асуулт асууж, саналаа хэлэх боломжтой. Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталгаажуулах, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах талаар саналаа аппаар болон цаасаар өгөх боломжтой. Санал хураалтын дүнг нэгтгээд, тогтоолын төслүүдээ та бүхэндээ танилцуулаад батлуулаад хурлаа хаана. Хувьцаа эзэмшигчдийн хуралд нь амжилт хүсье. Хэлэлцэх асуудлын дагуу Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатарыг танилцуулгаа хийхийг урьж байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН САНАЛ: *Хурлын дэгт холбогдуулан Хувьцаа эзэмшигчдээс санал гаргаагүй болно.*

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны танилцуулга:

Танилцуулга хийсэн Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар

Миний бие гүйцэтгэх захирлын ажлаа аваад нэг сар гаруйн хугацаа өнгөрч байна. Ард Кредит ББСБ-д 2017 оноос ажиллаж байгаа бөгөөд долоо дахь жилдээ ажиллаж байна. Өмнө нь миний бие гүйцэтгэх захирлын орлогчоор ажиллаж байсан. Ингээд компанийнхаа үйл ажиллагааны тайлангаа танилцуулъя.

Ард Кредит ББСБ нь байгуулагдаад нэгэн арваныг өнгөрөөсөн байна. Энэ хугацаанд компанийн стратеги маань финтекэд суурилсан нээлттэй компанийн засаглалтай байхыг төлөвлөж, дэд бүтэц үндсэн систем, үйл ажиллагаа явуулах зөвшөөрлөө зохицуулагч байгууллагаас авч та бүхний ашиглаж Ард апп 2018 онд бий болгож, 2021 онд хүүхдүүддээ зориулан Ард кидс, тогтмол орлоготой иргэдэд Ард аппаар үйлчилгээ авдаг байсан бол бизнесийн орлоготой иргэдэд чиглэн Good platform буюу нийлүүлэлтийн гинжин хэлхээний бизнесийг 2022 онд эхлүүлсэн байдаг. 2023 онд Монголбанкнаас карт гаргагчийн зөвшөөрлийг авч, бие даан Кредит картыг үйлчилгээнд нэвтрүүлээд байна. Мөн өнгөрөгч жил манай компани нэмэлт хувьцаа гаргах зөвшөөрлийг авч энэ оны эхний улирал нэмэлт хувьцааг хөрөнгийн бирж дээр гарган нийт 8,9 тэрбумын хөрөнгийг босгосон байна.

2022 онд 7 тэрбум төгрөгийн хаалттай бондыг Санхүүгийн Зохицуулах хороо, Арилжаа эрхлэгчийн холбооноос авч, 2023 оны эцэст бондыг амжилттай эргэн төлсөн. Монголбанкнаас Ард Кредит ББСБ ХК нь цахим мөнгө буюу төлбөр тооцооны хэрэгсэл, карт гаргагч, Аутсорсингийн үйлчилгээ гэсэн 3 зөвшөөрөлтэй ажилладаг. Технологи болон дэд бүтцийн хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэхдээ тодорхой шаардлагыг хангадаг энэ хүрээнд Аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрлийг өнгөрөгч онд авлаа. Хөрөнгө оруулагч үндэстэнг цогцлоох гэж байгаа бол Гадаад байгаа Монголчуудаа, Монголд байгаа гадаад хүмүүс ямар үйлчилгээг үзүүлэх вэ гэдэгт бодлого боловсруулж ажиллалаа. 2023 онд Ард санхүүгийн нэгдлийн багийхан маань Солонгос улс болон Чех улсад байгаа Монголчуудаа санхүүгийн боловсрлыг хүргэхээр очсон. Жил бүр Цахим хөгжлийн яам болон технологийн компаниуд хамтран финтек, цахим, дижитал эрэн үеийн хөгжил хаашаа чиглэж байна, үүнд хууль эрх зүйн зохицуулалт хэрхэн нийцэж байна гэдэг асуудлаар чуулдаг. Энэ чуулгад бид групп компаниараа амжилттай оролцсон. Санхүүгийн Зохицуулах хорооноос FPO нэмэлт хувьцаа гаргах зөвшөөрлийг авсан үүний талаар дараагийн танилцуулгад дэлгэрэнгүй ярина. Финтек үйлчилгээ буюу зээлийг цахимаар олгох үйлчилгээ нь Банк болон банк бус санхүүгийн байгууллагын хувьд тренд үйлчилгээ болоод байна. 2023 оны 6 дугаар сард ББСБ-д нилээдгүй зохицуулалт бий болсон. Банкнудын хувьд өр орлогын харьцааг 70:30 гэдэг шаардлагыг тавьдаг бол 60:40 гэдэг шаардлагыг тавьдаг болж бид үйлчилгээгээ энэхүү шаардлагад нийцүүлсэн.

Өмнө манай компани нээлттэй компани болох стратегийн зорилтыг өмнө тавьсан бол бид нээлттэй компанийн хувьд зохицуулагч байгууллагаас баталсан засаглалын бодлого буюу кодексийг хэрэгжүүлэх хүрээнд бид өнөөдөр хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй нээлттэй компаниудын засаглалын кодексийг хэрэгжүүлэгч топ-10 компанийн нэг болсон, энэ топ-10 компанийн нэг болох нь ганцхан жилийн үр дүн биш, бидний олон жилийн зорьж ажилласны үр дүнг зохицуулагч байгууллагаас бидэнд өгсөн үнэлгээ гэж

хардаг. Финтекээр зээлийн үйлчилгээ үзүүлэхэд мэдээллийн аюулгүй байдал маш их яригдаж байгаа, өнөөдөр бид мэдээллийн аюулгүй байдлын ISO/IEC 27001:2013 стандартыг нэвтрүүлэн ажиллаж байна. Энэ оны эхний улиралд компанийнхаа 30 хувийг иргэдэд нээлттэй зарласан, 8,900,000,000 төгрөгийг төвлөрүүлсэн. Ингэснээр бид зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сайжруулж байгаа, олон улсын төсөл хөтөлбөрөөс зээл авах боломжоо 36 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн.

2023 оны гол үзүүлэлтүүдийг товчхон харуулья. 2023 онд 13,700 хувьцаа эзэмшигчтэй, 2024 оны 4 дүгээр сарын байдлаар 14,860 хувьцаа эзэмшигчтэй байна. Монголын банк бус санхүүгийн байгууллагууд гэхээр нийт 570 орчим банк бус санхүүгийн байгууллагууд байдаг, энэ байгууллагууд дотроо хамгийн олон хувьцаа эзэмшигчтэй банк бус санхүүгийн байгууллага юм, энэ дашрамд хувьцаа эзэмшигч та бүхэндээ баярлалаа гэж хэлье. Ард Кредит ББСБ ХК-ийн хувьд 1 сая гаруй харилцагчтай, нэгдлийн компаниудын өмнө манай байгууллага харилцагчийн бүртгэл, комплаенс бүхнийг хариуцан эдгээр харилцагчийн өмнө үйлчилгээ үзүүлэх гүүрийг тавьдаг байсан. Зээлдэгч 65,000 байгаа, зээлдэгчийн тоог нэмэгдүүлнэ. Зээлдэгчийн тоог нэмэхэд бид цахимаар үйлчилгээ үзүүлэх гэрээг Монгол шуудан ХК-иар дамжуулан Баян-Өлгий аймагт гэрээ байгуулах боломжийг олгоно гэсэн зорилтыг тавьсан. Нийт хөрөнгө 72 тэрбум төгрөг, санхүүжилт 42.1 тэрбум төгрөг, эздийн өмч 20.9 тэрбум төгрөг болон нэмэгдсэн. Цэвэр ашгийн хувьд 2,5 тэрбумын ашигтай ажилласан, зээлийн багцийн хувьд 49,6 тэрбум, зээл олголт 104.3 тэрбум, зээлийн төлөлт 94.7 тэрбум төгрөг байгаа. Эдгээр харьцаанаас харах юм бол Банк бус санхүүгийн байгууллагын стандарт буюу дундажтай адил хэмжээнд буюу 7.4 хувьтайгаар 2023 оныг үдсэн байна.

Санхүүгийн гол үзүүлэлтийн танилцуулга:

Танилцуулга хийсэн Санхүү эрхэлсэн захирал Д.Лхагва-Очир

Миний бие Санхүүгийн тайлан болон санхүүгийн гол үзүүлэлтийн талаар танилцуулья. 2023 он бидний хувьд эрүүл өсөлтийг үзүүлсэн тогтворжилтийн жил байсан. Нийт хөрөнгийн хувьд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24 хувиар нэмэгдэж, 72 тэрбумд хүрсэн, энэ нь 2021 оны өндөр үзүүлэлтдээ хүрсэн. Зээлийн багц 18 хувиар нэмэгдэж, 2023 оны жилийн эцсийн байдлаар 49,6 тэрбумд хүрсэн. Зээлийн багц нэмэгдэхийн гол эх үүсвэр шалтгаан нь бусдаас татан төвлөрүүлсэн, итгэлцэл, зээл, бонд, гаднын санхүүжилт байдаг. Энэ санхүүжилтийн хэмжээг хэрхэн нэмэгдүүлснээрээ өөрийн хөрөнгө, зээлийн багцаа нэмэгдүүлдэг. Нөгөө талдаа санхүүжилтийн хэмжээ 42,1 тэрбумд хүрч өмнөх оны мөн үеэс 30 хувиар нэмэгдсэн. Энэ өсөлт нь ашигт ажиллагаа, өөрийн хөрөнгийн өсөлтөд гол нөлөөллийг үзүүлсэн. Өмнө нь гүйцэтгэх захирлын хэлсэнчлэн өнгөрсөн оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийнхаа 30 хувийг нэмж гаргах шийдвэрийг гаргаж, 2024 оны эхний улиралдаа багтаан нэмэлт хувьцаагаа амжилттай гаргасан. Нэмэлт хувьцаанд 1,500 гаруй хувьцаа эзэмшигчид оролцож, 9,1 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж үүнээс 8,900,000,000 төгрөгийн захиалга биелсэн. Цаашид 36 тэрбум төгрөгөөр санхүүжилт татах боломжтой болж бидэнд дараагийн том өсөлтийг хийх нөхцөл байдал бүрдсэн байна.

Зээлийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Зээлийн олголт маань өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 хувь, зээлийн эргэн төлөлт 17 хувиар өссөн байна. Зээлийг олгоод зээл өсөөд байдаг ямар чанартай зээл гаргасан бэ гэдэг Банк бус санхүүгийн байгууллагын хувьд чухал үзүүлэлт байдаг. Чанаргүй зээлийн хувь болон эрсдэлтэй зээлийн хувь маань өмнөх оны мөн үеэс буурсан. Энэ нь зээл олгохдоо чанартай, зөв бүтэцтэй, зөв скорингтойгоор зөв сигменттэйгээр олгосон болохыг нь харагдаж байна. Та бүхэнд дараагийн слайдаараа санхүүгийн аудитлагдсан тайлангаа танилцуулж байна. Өнгөрсөн жил санхүүжилт нэмэгдэж, зээлийн багц нэмэгдсэн гэж өмнө хэлсэн үүнтэй холбоотойгоор хүүгийн орлого өссөн байгаа, гол үйл ажиллагаараа орлогоо олсон гэсэн үг. Зардлуудын хувьд төсөвтөө байсан, 2023 оны эцсийн байдлаар 2,5 тэрбумын цэвэр ашигтай буюу өмнөх оны мөн үеэс 22 хувийн өсөлттэй байсан. Санхүүгийн тайлан болон балансийн хувьд харахад мөнгөн хөрөнгө нэмэгдсэн, мөнгөн хөрөнгө 44 хувиар нэмэгдсэн. Мөнгөн хөрөнгө нэмэгдэх нь Банк бус санхүүгийн байгууллагын хувьд харилцагчид итгэлцлээ цуцлая гэх зэргээр төлбөрийн асуудал үүсэхэд бэлэн байх зорилгоор төлбөрийн чадварийн үзүүлэлт сайжирсан. Үндсэн зээл олголтын үйл ажиллагаа явуулахаас гадна СЗХ-оос авсан богино хугацаат төлбөрийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрлийн хүрээнд 2023 оны эцсийн байдлаар 10 хувьцаанд хөрөнгө оруулсан. Төлөөлөн удирдах зөвлөлийн онцлох шийдвэрийн хэсэгт танилцуулагдах байх. Бид бүхэнд Хасбанканд хөрөнгө оруулалт хийсэн. Банк бус санхүүгийн байгууллагад зохистой харьцааны 20 үзүүлэлтийг тайлагнадаг дэлгэцэнд онцлох 6 үзүүлэлтийг харуулалаа. Өөрийн хөрөнгийн өгөөж буюу ашигт ажиллагааны үзүүлэлт өмнөх

оны мөн үетэй харьцуулахад сайжирсан болохыг, хөрвөх чадварын үзүүлэлт 8 хувьтай байхыг шаарддаг бол бид 14 хувьтайгаар үзүүлэлтийг давуулан биелүүлж ажиллаж байна. Мөн гол үзүүлэлт болох холбоотой этгээдийн зээлийн харьцааг барьж зээлийн багцаа төрөлжүүлэн ажиллаж байна. Эрсдлийн сангийн хүрэлцээ нь эрсдэл даах чадвар хэр байгааг эргээд энэ санг байгуулсан, санхүүгийн тайланд тусгасан эсэхийг СЗХ хардаг. Үүнээс харахад эрсдлийн сангийн хүрэлцээ эерэг буюу илүүдэлтэй байна гэдэг нь ирээдүйд учрах эрсдлийг хаах хэмжээний байна. Дэлгэцэнд хувьцаа эзэмшигчид та бүхний хамгийн их сонирхдог хувьцааны ханшны талаарх мэдээллийг харуулж байна. 2023 оны хувьд нэгж хувьцаа 100-130 төгрөгийн хооронд хэлбэлзсэн. Нэмэлт хувьцааг 106 төгрөг буюу зах зээлийн үнээс хямдралтай үнээр гаргахыг зарласантай холбоотойгоор хувьцааны үнэ нэмэлт хувьцаа зарласан ханшийн орчимд арилжаалагдаж байгаа. Үүнд хөрөнгө оруулагч та бүхэнд хамгийн анхаарбал зохих үзүүлэлт нь P/E, P/B буюу манай балансад бүртгэлтэй нэг төгрөгийг зах зээл хэдэн төгрөгөөр үнэлээд байна вэ гэдэг нь P/B харьцаа харуулдаг. P/B нь оны эцсийн байдлаар 1,6 нэгдүгээр улирлын байдлаар 1,4 байна, зах зээлийн дундаж нь 2 үнэлсэн байна. Энэ нь бусад банк бус санхүүгийн байгууллагатай харьцуулахад харьцангуй доогуур үнэлэгдсэн буюу хөрөнгө оруулалт хийхэд тохиромжтой үе дээрээ явж байна. 2023 оны эцсийн байдлаар манай компани нийт 289,000,000 хувьцаа эзэмшигчтэй байсан. Манай хамгийн том хөрөнгө оруулагч Ард санхүүгийн нэгдэл болон түүний хамаарал бүхий компаниуд 58.5 хувийг эзэмшиж байсан. Нэмэлт хувьцаа гаргасны дараа 60 хувь болж нэмэгдсэн.

ТУЗ-ийн 2023 оны шийдвэрээр ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэж, нэгж хувьцаанд 0.1 ширхэг ардквойныг урамшуулал хэлбэрээр олгосон, дэлгэцэнд ардквойны тайланг харуулсан байна.

2. Компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулга

Танилцуулга хийсэн: Грант Торнтон Аудит ХХК-ийн менежер С.Уянга

Грант Торнтон Аудитын компанийн талаар товч танилцуулгыг хүргэе. Бид дэлхийн 140 гаруй улс орны 62,000 гаруй мэргэжилтнүүдээс бүрдсэн баталгаажуулалт, татвар, зөвлөх үйлчилгээний дэлхийн зургаан том фирмийн нэг юм. Аудитын салбарт 25 жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай компани юм. Ард Кредит ББСБ ХК-тай 2019 оноос хойш, 4 жилийн турш санхүүгийн тайланд аудит хийж, аудитын тайлан, дүгнэлтийг хүргүүлж байна. Дүгнэлтээ гаргахдаа материаллаг байдал гэдэг зүйлийг харгалзаж үздэг. Материаллаг байдал гэж юуг хэлж байгаа вэ гэхээр санхүүгийн тайланд бид дүгнэлтээ илэрхийлэхдээ ямар нэг материаллаг дүнгээр буруу илэрхийлэгдээгүй гэдэг агуулгыг илэрхийлдэг. Материаллаг байдал гэдгийг бид яаж үзсэн бэ гэхээр татвар төлөхийн өмнөх ашгийн 7 хувь юм уу, нийт орлогын 3 хувийг харьцуулж байгаад нийт 423 сая төгрөгөөр материаллаг байдлыг тогтоосон. Манай аудитын баг бүрэлдэхүүн бол 68 өдөр 6 хүний бүрэлдэхүүнтэй 43 хоног ажиллаж жилийн эцсийн аудитыг нь гүйцэтгэсэн. Аудитаас Ард Кредит ББСБ-ийн санхүүгийн тайланд эерэг буюу СЗХ-ны журам, зааварт заасан аргачлалын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн, стандарт үнэлгээг өгсөн.

3. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ гаргасан дүгнэлтийг хэлэлцүүлэх

Танилцуулга хийсэн: ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Солонго

Миний бие 2021 оны 7 дугаар сараас эхлэн Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллаж байгаа. Нэг ёсондоо та бүхний буюу 13,700 хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг төлөөлөөд байж байгаа гишүүн. Хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид маань ТУЗ-ийн бүрэлдэхүүнээ сайн мэдэх байх, шинэ гишүүдэдээ зориулаад ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүнээ танилцуулах нь зүйтэй байх гэж үзсэн. ТУЗ даргаар хурлын дарга Ч.Ганзориг, 3 хараат бус гишүүнтэй, 6 ердийн гишүүнтэй. Эдгээр гишүүдээ хувьцаа эзэмшигчид маань өөрсдөө сонгодог гэдгийг та бүхэн маань мэдэж байгаа. ТУЗ дотроо Засаглал нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Дотоод аудитын хороо, 3 хороотойгоор үйл ажиллагааг явуулж байна. Аудитын хороо нь төлөвлөгөөний дагуу ажиллаж байна уу, ашиггүй зардлыг гаргаж байна уу гэдгийг хянадаг хороо гэсэн үг, энэ хороог хараат бус гишүүн В.Ганзориг маань ахалдаг. Санхүү, Зээл, эрсдлийн хорооны үйл ажиллагааг О.Одбаяр гишүүн маань ахалдаг. Өнгөрсөн онд нийт 68 хурал хийж, ээлжит 5 хурал, эчнээ 63 хурлыг хийж, 81 шийдвэрийг гаргасан. Хороодууд маань 11 удаа хуралдаж 27 зөвлөмжийг ТУЗ-даа өгсөн байна. 2023 оны томоохон шийдвэрүүдийг танилцуулъя. 2023 оны 3 дугаар сарын 06-ны өдөр Хувьцаа эзэмшигчдэдээ нэгж хувьцаанд 0.1 ширхэг АрдКвойныг хувь тэнцүүлэн



урамшуулал олгохоор, 2023 оны 5 дугаар сарын 08-ны өдөр Хөх Тэнгэр төсөлд 1.5 тэрбум төгрөгөөр хөрөнгө оруулалт хийхээр, 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдөр ХасБанкны IPO-д хөрөнгө оруулт хийхээр, 2023 оны 5 дугаар сарын 19-ний өдөр Компанийн 30% буюу 84,000,000 ширхэг хувьцаа нэмж гаргахаар тус тус шийдвэрлэж, 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр 2023 оны жилийн эцсийн Аудит хийх компаниар Грант Торнтон аудит сонгосон.

Ингээд Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ дүгнэлтийг танилцуулъя.

Компанийн тухай хуулийн 76 дүгээр зүйлийн 76.1.11 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хурлаар хэлэлцэн компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар танилцуулж байна.

2023 оны туршид 1.4 тэрбум төгрөгийн 12.2 сая ширхэг компанийн хувьцаа арилжаалагдаж компанийн хувьцаа эзэмшигчдийн тоо 13,700 болсон байна. Зээлийн багц 41.8 тэрбум төгрөгөөс 49.6 тэрбум төгрөг, нийт актив 58.0 тэрбум төгрөгөөс 72.0 тэрбум төгрөгт хүрч 2023 онд 2.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллан компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөний хэрэгжилт 87 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Мөн “Ард Кредит ББСБ” ХК нь Монголбанкнаас Аутсорсингийн үйлчилгээ авах тусгай зөвшөөрлийг авч, Кредит картыг хэрэглээнд нэвтрүүлж 1,040,000 хэрэглэгч, харилцагчтай болж, хэрэглэгч, харилцагчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, үйл ажиллагаагаа олон улсын стандартад нийцүүлэн Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн ISO/IEC 27001:2013 стандартыг нэвтрүүлсэн байна.

Хурлын дарга Ч.Ганзориг: Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ дүгнэлтийг танилцуулсан Б.Солонгодоо баярлалаа. Хувьцаат компанийн хувьд ТУЗ хараат бус гишүүд маань жижиг хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн ТУЗ-д ажилладаг. Манай хараат бус Б.Энхчимэг, Б.Солонго, В.Ганзориг гишүүд маань маш идэвхитэй ажилладаг. Бид энэ жил ТУЗ-ийн шийдвэр гараад ногдол ашиг хуваарилсан. Энэ талаар Сүхбаатар захирал танилцуулна. 2019 онд IPO хийсэн цагаас хойш ногдол ашиг хуваарилж ирсэн. 2022 онд олгоогүй ч койноороо хувьцаа эзэмшигчдээ урамшуулсан. Нийт 5.3 тэрбум төгрөгийн ногдол ашгийг олгосон байна. Анх 5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж байсантай харьцуулаад үзэхэд 5.3 тэрбум төгрөгийг буцаан олгосон байна. Дэгийнхээ дагуу ногдол ашиг хуваарилсан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулна уу хэмээн гүйцэтгэх захирал Г.Сүхбаатарыг урья.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН САНАЛ: Хувьцаа эзэмшигчид ТУЗ-ийн дүгнэлттэй холбогдуулан санал гаргаагүй болно.

4. 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах

Танилцуулга хийсэн: Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар

2024 оны 03 сарын 07-ны өдөр ТУЗ-ийн тогтоол гарсан. 5.3 тэрбум төгрөгийн цэвэр ашгийн 40 хувь буюу 1,019,200,000 төгрөгийн ногдол ашгийг тараахаар шийдвэрлэж, 2024 оны 04 сарын 22-ны өдрөөс хувьцаа эзэмшигч та бүхний төвлөрсөн хадгаламжийн данс руу олгосон.

5. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэх

Танилцуулга хийсэн: Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар

Компанийн дүрэмд нэмэгдсэн заалтуудыг танилцуулъя. Та бүхэн сайн мэдэх байх бид бүх бүтээгдэхүүн үйлчилгээ авах бүрт Ард Койнаар урамшуулдаг. Үүнийг дүрмэн дээр оруулах санал дээр 1.5. Компани нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч, үйлчлүүлэгч, ажилтнуудаа урамшуулах зорилгоор өөрсдийн урамшууллын оноо Ард Койныг ашиглана. Энэ нь бусад хэлбэрээр урамшуулал олгохыг хориглох заалт болохгүй. Компанийн дүрмийн төслийг хувьцаа эзэмшигч нар урьдчилсан байдлаар хүргүүлсэн. Дүрмийн 1.5 дахь заалтыг урьдчилсан байдлаар толгой компаниуд болон хөрөнгө оруулагч нарт бүгд дэмжсэн. Харин 2.1 дээр эрхэм зорилгоо нэгтгэх тал дээр санал нэгтэй, мөн алсын хараа финтек нэгдэл болон хөрөнгө оруулагч үндэстэн болох зэрэг саналууд гарч ирсэн. Компанийн тухай

хуульд зааснаар бид төслийг хурлаараа хэлэлцэн батлахаар заасан байгаа. Иймд та бүхэн дүрмийн төслийн талаар саналаа хэлэх, асуулт асуух бүрэн боломжтой.

Ард Кредит ББСБ ХК нь Ард Санхүүгийн нэгдлийн оролцогч компанийн хувьд үйл ажиллагаа явуулахдаа дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах чиглэлээр ажиллаж байна. Энэхүү өдөр тутмын үйл ажиллагаагаа зөвлөлдөж явуулж байгаагаа дүрмэндээ оруулах зорилгоор та бүхэнд танилцуулж буй 9.6, 9.7, 9.8 дахь заалтуудыг оруулсан урьдчилсан санал хураалтаар дээрх заалтуудыг саналын эрхтэй ихэнх хувьцаа эзэмшигч нар дэмжээгүй, дүрмийн 1.5 болон 2.1 дэх саналууд л дэмжигдсэн байсан болохыг дурдах нь зүйтэй байх.

Дүрмийн 1.4 дэх заалтад Компани нь Хүчтэй.Хамтдаа. гэсэн уриа үгтэй байхаар дүрэмд оруулж өгсөн. Компанийн хуульд нийцүүлэн 4.2 дахь заалтад Компани нь өөрийн хувьцаа эзэмшигчдийн хариуцлагыг хүлээхгүй мөн хувьцаа эзэмшигчид нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ гэж нэмж өөрчлөлт оруулсан. Мөн дүрмийн 4.4 дэх заалтыг хуульд нийцүүлэн Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Монгол Улсын Компанийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.

ГРО гаргасантай холбогдуулан компанийн хувьцаа эзэмшигчдийн тоо нэмэгдэж, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн талаар дээр дурдсан үүнтэй холбоотойгоор дүрмийн 6.1 дэх заалтад Компанийн нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 364,000,000 (гурван зуун жаран дөрвөн сая) ширхэг хувьцаатай байна. Компанийн 6.2 дахь заалтад компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 3,640,000,000 (гурван тэрбум зургаан зуун дөчин сая) төгрөг байх ба гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүн буюу хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн нийт хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ гэж өөрчлөлтүүдийг оруулсан.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН САНАЛ: Дүрмийн шинэчилсэн найруулгын төслийн 9.6, 9.7, 9.8 зүйлүүдийг тус тус хасах, 2.1-т заасан алсын харааг 2.2 дахь заалтаар оруулж саналыг Компанийн хувьцаа эзэмшигчид гаргасан болно.

6. Хэлэлцэх асуудалтай холбоотой, асуулт хариулт

Хувьцаа эзэмшигчдийн тавьсан асуултад Хурлын дарга Ч.Ганзориг болон бусад албан тушаалтнууд зохих хариуг өгсөн болно.Санал гараагүй болно.

7. Саналын хураалтын дүнг нэгтгэх, танилцуулах

Тооллогын комисс Ө.Бямбагэрэл:

Хувьцаа эзэмшигчдийн санал хураалтыг нэгтгэн танилцуулахад бэлэн болоод байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь хэсэгт заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн санал болон Ард Аппаар ирүүлсэн саналын дүнг нэгтгэснийг үндэслэн Тогтоох нь: Хурлаар хэлэлцсэн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан талаар ТУЗ-ын дүгнэлтийг батлах тухайд 285.206.770 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсаар болон Ард Аппаар 285.106.073 санал буюу 99.96 хувийн зөвшөөрсөн санал өгч дэмжигдлээ.

Хурлаар хэлэлцсэн Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудал буюу Компанийн дүрмийн 4.1.4, 4.2, 4.4, 6.1, 6.2 дахь заалтыг өөрчлөх, Компанийн дүрмийн 1.5, 2.1, 2.2 дахь заалтыг нэмснийг хуралд оролцсон 285.206.770 хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар 285.131.121 санал буюу 99.97 хувийн зөвшөөрсөн саналаар тус тус дэмжигдлээ.

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.9 дэх заалтад тус тус зааснаар 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах болон Компанийн дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудал нь тус тус батлан шийдвэрлэлээ.

Хурлын дэгийн дагуу Ард Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг танилцуулж, энэхүү хурлын хаана уу хэмээн Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ-ийн дарга Ч.Ганзориг танийг энэхүү тайзан дээр урьж байна.

8. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг уншиж танилцуулъя.



Хурлын дарга Ч.Ганзориг:

Тогтоол 1. 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан батлах тухай

Компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай Компанийн тухай хуулийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6, 7.9 дэх хэсэг, 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ард Кредит ББСБ” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар удирдах зөвлөлийн 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 21 тогтоолоор гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай.

Тогтоол 2. Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, Компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4.1, 7 дугаар зүйлийн 7.6, 7.9 дэх хэсэг, болон 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 03 тоот тогтоолыг дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Компанийн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулсугай.

1.1. Компанийн дүрмийн 1.4 дэх хэсэгт “Компани нь Хүчтэй.Хамтдаа. гэсэн уриа үгтэй байх бөгөөд компанийн бэлгэдэл тэмдэг нь байх ба АРД гэсэн улаан гурван үсгээс бүрдсэн байх ба хажууд нь Кредит ББСБ гэж бичсэн байна” гэж;

1.2. Компанийн дүрмийн 4.2 дахь хэсэгт “Компани нь өөрийн хувьцаа эзэмшигчдийн хариуцлагыг хүлээхгүй мөн хувьцаа эзэмшигчид нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ” гэж;

1.3. Компанийн дүрмийн 4.4 дэх хэсэгт “Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Монгол Улсын Компанийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.” гэж;

1.4. Компанийн дүрмийн 6.1 дэх хэсэгт “Компанийн нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 364,000,000 (гурван зуун жаран дөрвөн сая) ширхэг хувьцаатай байна.” гэж; 1.5. Компанийн дүрмийн 6.2 дахь хэсэгт “Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 3,640,000,000 (гурван тэрбум зургаан дөч сая) төгрөг байх ба гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүн буюу хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн нийт хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ.” гэж тус тус өөрчлөх;

2. Ард Кредит ББСБ ХК-ийн Компанийн дүрэмд дараах нэмэлтийг оруулсугай.

2.1. Компанийн дүрмийн 1.5 дахь хэсэгт “Компани нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч, үйлчлүүлэгч, ажилтнуудаа урамшуулах зорилгоор өөрсдийн урамшууллын оноо АрдКойныг ашиглана. Энэ нь бусад хэлбэрээр урамшуулал олгохыг хориглох заалт болохгүй” гэж;

2.2. Компанийн дүрмийн 2.1 дэх хэсэгт “Компани нь Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоох эрхэм зорилготой ажиллана” гэж;

2.3. Компанийн дүрмийн 2.2 дахь хэсэгт “Салбарын хөгжлийг түүчээлэгч” алсын хараатай ажиллана” гэж;

3. Энэхүү шийдвэрийн 1, 2 дахь хэсэгт заасан нэмэлт, өөрчлөлт оруулсан Компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.

4. Энэхүү шийдвэрийн хавсралтаар баталсан Компанийн дүрмийг хууль, тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох бусад байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Г.Сүхбаатар/-т даалгасугай.

5. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавихыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ч.Ганзориг/-т даалгасугай.

Өнөөдрийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн хурал өндөрлөж, хурлыг хааж байна.

ХУРЛЫН ДАРГА:

Ч.ГАНЗОРИГ

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Д.МӨНХ-ОД

